| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 3,695,754,600.00 | 3,373,558,151.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 3,695,754,600.00 | 3,373,558,151.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 81,409,600.00 | 81,409,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 30,059,900.00 | 30,059,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 51,349,700.00 | 51,349,700.00 |
| 13 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 8,238,568,000.00 | 7,770,197,105.61 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 7,813,027,300.00 | 7,621,530,562.61 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 7,400,687,000.00 | 7,209,190,262.61 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 412,340,300.00 | 412,340,300.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 425,540,700.00 | 148,666,543.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 277,500,000.00 | 148,666,543.00 |

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-----------|--|----------------|----------------|
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 148,040,700.00 | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 300,121,186.60 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 188,933,078.60 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 48.00 | 48.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 48.00 | 48.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 484.00 | 110.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 17.00 | 5.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 14.00 | 53.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 453.00 | 43.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | | 9.00 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 484.00 | 110.00 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 14.00 | 23.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 454.00 | 60.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | | 9.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 16.00 | 18.00 |

2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 508,419,854.00 | 228,642,850.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 457,358,254.00 | 228,642,850.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 440,086,241.00 | 227,085,700.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,600,000.00 | - |
| 210101 | Үндсэн цалин | 1,600,000.00 | |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,900,000.00 | - |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,900,000.00 | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 18,224,315.00 | 3,149,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,566,509.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,246,080.00 | 3,109,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 604,326.00 | 40,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,217,400.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,590,000.00 | |
| 2105 | Нормативт зардал | 755,000.00 | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 755,000.00 | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,800,000.00 | - |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,800,000.00 | |
| 2107 | Томилолт, зочны зардал | 530,831.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 530,831.00 | |

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|---|----------------------|---------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 865,000.00 | - |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 865,000.00 | |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 412,411,095.00 | 223,936,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 360,283,909.00 | 223,936,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 52,127,186.00 | |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 16,800,000.00 | - |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 16,800,000.00 | - |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 16,800,000.00 | |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 472013.00 | 1,557,150.00 |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 472,013.00 | 1,557,150.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 51,061,600.00 | - |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 51061600.00 | - |
| 225001 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 51,061,600.00 | |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 508,219,854.00 | 228,642,850.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 508,219,854.00 | 228,642,850.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 715,000.00 | 8,621,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 436,651,473.00 | 204,950,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 70,853,381.00 | 15,071,350.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | (200,000.00) | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 200,000.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 200,000.00 | |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь “Хүний нөөц, газар, байгалийн баялаг, дэд бүтцийн давуу талдаа тулгуурласан газар тариалан, үйлдвэр, аялал жуулчлал, нийгмийн үйлчилгээний харилцаа бие биеэ нөхөх зөв зохистой бүтэц бүхий цогц салбаруудыг хөгжүүлж, хүн амын амьдрах таатай орчныг бүрдүүлсэн сум болно” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 18 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг байна.

Тус төсвийн төвлөрүүлэн захирагчийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 37,349.9 сая төгрөгөөр буюу 60.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|---------------------|---------------------|----------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 537,207.6 | 190,899.2 | -346,308.4 |
| Авлага | 930,843.4 | 818,198.2 | -112,645.2 |
| Урьдчилж гарсан зардал | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 1,100,441.6 | 22,331.6 | -1,078,110.0 |
| Үндсэн хөрөнгө | 59,250,436.6 | 23,437,526.7 | -35,812,909.9 |
| Нийт хөрөнгө | 61,818,929.3 | 24,468,955.7 | -37,349,973.6 |
| Өр төлбөр | 482,277.3 | 347,268.4 | -135,008.9 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 61,336,652.0 | 24,121,687.3 | -37,214,964.6 |

/мянган төгрөгөөр/

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|--|---------------------|---------------------|----------------------|
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 61,818,929.3 | 24,468,955.7 | -37,349,973.6 |
|--|---------------------|---------------------|----------------------|

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр, үндсэн хөрөнгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Ерөнхий боловсрол, сургуулийн өмнөх боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын бүтцийн өөрчлөлттэй холбоотой шилжүүлсэн хөрөнгийн дүнгээр дээрх дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 190.9 сая төгрөг болж, өмнөх оноос 346.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

| Үзүүлэлт | /сая төгрөгөөр/ | | |
|-----------------------------------|-----------------|-----------------|------------------------|
| | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
| Кассад байгаа бэлэн мөнгө | 0.6 | | -0.6 |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 536.6 | 190.9 | -345.7 |
| Төгрөг | | | |
| Төрийн сангийн харилцах | 462.4 | 190.9 | -271.5 |
| Арилжааны банк дахь харилцах | 74.2 | | -74.2 |
| Гадаад валют | | | |
| Арилжааны банк дахь харилцах | | | |
| Замд яваа мөнгөн хөрөнгө | | | |
| Дүн | 537.2 | 190.9 | -346.6 |

Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эцэст 190.9 сая төгрөг байгаагаас сумын Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 2.0 сая төгрөгийн, ОНХС-д 25.1 сая төгрөгийн, Хоршоо хөгжүүлэх сангийн дансанд 163.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчил гараагүй байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 930.8 сая, эцсийн үлдэгдэл 818.2 сая төгрөг болж, 112.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

| Үзүүлэлт | /сая төгрөг/ | | |
|---------------------------------|----------------|-----------------|------------------------|
| | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 15.2 | 3.6 | -11.6 |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 43.1 | 0 | -43.1 |
| Татаас, санхүүжилтийн авлага | | | - |
| Зээлийн хүүгийн авлага | | | - |
| Бусад авлага | 202.8 | 1.9 | -200.9 |
| Зээлийн авлага | 669.7 | 812.7 | 143.0 |
| Дүн | 930.8 | 818.2 | -112.6 |

Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хоршоо хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэл 812.7 сая төгрөг байгаа нь нийт авлагын 99.3 хувийг эзэлж байна. Тайлант онд авлагын эргэн төлөлтөөс нэмж зээл олгосон байна. Зээлийн авлага 812.6 сая төгрөг болж оны эхнээс 143.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Төсөвт байгууллагуудаас сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд 0.5 сая төгрөгийн, Засаг даргын тамгын газарт 5.1 сая төгрөгийн бусад авлага шинээр нэмэгдсэн байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай авлага байхгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Авлагатай холбоотой алдаа зөрчил гараагүй байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 1,100.4 сая, эцсийн үлдэгдэл 22.3 сая төгрөг болж, 1,078.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---------------------|----------------|-----------------|------------------------|
| Түүхий эд материал | 122.1 | | -122.1 |
| Хангамжийн материал | 978.3 | 22.3 | -956.0 |
| Дүн | 1,100.4 | 22.3 | -1,078.1 |

Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөвт байгууллагууд төсвийн хөрөнгөөр 137.6 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч данс бүртгэлд тусгаж, 164.0 сая төгрөгийг зарцуулж, боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагын 1,051.7 сая төгрөгийн бараа материалыг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн байна.

Бараа материалын нийт үлдэгдлийн 9.8 сая төгрөг нь Хот тохижилтын албаны, 12.5 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудын үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материалтай холбоотой алдаа зөрчил гараагүй байна.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгийн данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 23,437.5 сая төгрөг болж, өмнөх оноос 35,812.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---------------------|-----------------|-----------------|------------------------|
| Биет хөрөнгө | 53,066.7 | 19,072.7 | -33,994.0 |

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|--|-----------------|-----------------|------------------|
| Барилга, байгууламж, орон сууц | 32,426.6 | 1,323.9 | -31,102.7 |
| Авто-тээврийн хэрэгсэл | 468.3 | 1,360.3 | 892.0 |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 2,645.8 | 126.0 | -2,519.8 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 1,804.9 | 105.5 | -1,699.4 |
| Бусад үндсэн хөрөнгө | 19,414.0 | 19,644.7 | 230.7 |
| Дуусаагүй барилга, байгууламж | 3,845.0 | - | |
| Биет бус хөрөнгө | 6,183.7 | 4,364.8 | -1,818.9 |
| Программ хангамж | 12.3 | 0.2 | -12.1 |
| Бусад биет бус хөрөнгө | 6,171.4 | 4,364.6 | -1,806.8 |
| Бусад хөрөнгө /ТӨҮГ/ | | | |
| Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/ | | | |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ + Бусад | | | |
| Дүн | 59,250.4 | 23,437.5 | -35,812.9 |

Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 6.8 сая төгрөг, хандиваар 2,071.7 сая төгрөгөөр нэмэгдсэн, боловсрол, соёл, эрүүл мэндийн 41,962.9 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой зөрчил дутагдал гараагүй байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 347.3 сая төгрөг болж, өмнөх оноос 135.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | / сая төгрөгөөр/ | |
|---------------------------------------|----------------|-----------------|------------------|-----------------|
| | | | Өссөн+ Буурсан - | Дүнд эзлэх хувь |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 42.4 | 5.5 | -36.9 | 1.6 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 38.7 | - | -38.7 | |
| Байгууллагад төлөх өглөг | 362.2 | 35.9 | -326.3 | 10.3 |
| Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг | 39.0 | 305.9 | 266.9 | 88.1 |
| Нийт дүн | 482.3 | 347.3 | -135.0 | 100.0 |

Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эхний 38.7 сая төгрөгийн бараа үйлчилгээний зардлын өглөгийг барагдуулсан байна. Хот тохижилтын алба 35.9 сая төгрөгийн, Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг 305.9 сая, ИТХ 5.5 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөгтэй гарсан байна.

Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг оны эхэнд 39.0 сая төгрөг байсан бөгөөд оны эцэст 305.9 сая төгрөг болж 266.9 сая төгрөгөөр өссөн нь аймгийн төсөвт төлөх өглөг бөгөөд сумын 2022 оны орон нутгийн орлогын төлөвлөгөө 517.1 сая төгрөгөөр тасарснаас төлөх боломжгүй болж, өглөгөөр тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

Өглөгтэй холбоотой алдаа зөрчил гараагүй байна.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 24,121.7 сая төгрөг болж, өмнөх оноос 37,215.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | / сая төгрөгөөр/ | |
|---|-----------------|------------------|------------------------|
| | | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 14,965.5 | 5,370.4 | -9,595.1 |
| Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | | | |
| Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | | | |
| Хуримтлагдсан үр дүн | | | |
| Өмнөх үеийн үр дүн | 17,550.1 | 55,630.1 | 38,080.0 |
| Тайлант үеийн үр дүн | 16,614.2 | -37,331.1 | -11,754.6 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 12,206.9 | 452.3 | -977.7 |
| Дүн | 61,336.7 | 24,121.7 | -37,215.0 |

Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын бүтцийн өөрчлөлттэй холбоотой Засгийн газрын оруулсан капитал дансанд 9,601.1 сая, хөрөнгийн дахин үнэлгээний нөөц дансанд 11,754.6 сая төгрөгийн бууруулах бичилт, өмнөх үеийн үр дүн дансанд 21,465.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэх бичилт хийгдсэнтэй холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 37,215.0 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Өлгий сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвийн нийт зарлагыг 9,229.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээр төсвийг 8.238.6 сая төгрөгөөр баталсан байна.

Нийт зардлын 7,400.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 412.3 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Өлгий сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 онд гүйцэтгэлээр нийтдээ 7,770.2 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого бүрдүүлснээс орон нутгийн төсвөөс 7,357.9 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 412.3 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч орлого бүрдүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 148.7 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлагын эргэн төлөлтийн орлого байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,881.4 сая төгрөг буюу 95.7 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлого, мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй холбоотой байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Аймгийн ИТХ-ын 2022 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 51 дугаар тогтоолоор Өлгий сумын 2022 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 7,274.9 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны “2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 2022 оны 93 дугаар тодотголоор 7,565.9 сая төгрөгөөр тодотгож, 291.0 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Сумын ИТХ-ын 2022 оны 36 дугаар хуралдааны тогтоолоор 2022 орлогын төлөвлөгөөг 7,565.9 сая төгрөгөөр хэвээр нь баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 7,048.8 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 93.2 хувиар биелүүлж, төлөвлөгөө 517.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт №2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Өсөлт/+, бууралт -/- | Дүнд эзлэх хувь |
|------------------------|----------------|----------------|-------------------------|--------------------|
| I.Татварын орлого | 6,892.8 | 6,448.7 | -444.1 | 91.5 |
| II.Татварын бус орлого | 673.1 | 600.1 | -73.0 | 8.5 |
| Нийт дүн | 7,565.9 | 7,048.8 | -517.1 | 100.0 |

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татвар 136.1 сая төгрөгөөр, үйл ажиллагааны орлогын татвар 77.1 сая төгрөгөөр, бууны албан татвар 3.6 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 27.7 сая төгрөгөөр, газрын төлбөр 11.8 сая төгрөгөөр, малын албаны татвар 0.1 сая төгрөгөөр, бусад орлого 148.2 сая төгрөгөөр давж биелэгдсэн нь төлөвлөгөөний биелэлтэд голлон нөлөөлсөн байна.

Хөрөнгийн орлогын татвар 333.9 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлогын татвар 72.3 сая төгрөгөөр, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 253.0 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хураамж 9.7 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 26.8 сая төгрөгөөр, ус ашигласны төлбөр 4.7 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлого 55.0 сая төгрөгөөр, бусад нэр заагдаагүй орлогоос 166.3 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 162.3 сая төгрөгийн, оны эцэст 1.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба орон нутгийн орлогын 995 тоот дансаар 7,083.0 сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №3 Төсвийн байгууллагуудын 2022 оны төсвийн зарлагын гүйцэтгэл:

/сая төгрөг/

| Д/д | Байгууллагын нэр | Батлагдсан төсөв | Гүйцэтгэл | Хэтрэлт, хэмнэлт |
|-----|--|------------------|----------------|------------------|
| 1 | ИТХурал | 211.9 | 211.9 | - |
| 2 | ЗДТГазар | 931.9 | 923.6 | -8.3 |
| 3 | Ерөнхий боловсролын сургуулийн байгууллага | 1,174.4 | 1,155.3 | -19.1 |
| 4 | Хүүхдийн цэцэрлэгийн байгууллага | 1,772.4 | 1,767.9 | -4.5 |
| 5 | ХТАлба | 177.5 | 177.5 | - |
| 6 | Хотгор Эрүүл мэндийн төв | 4.8 | 3.4 | -1.4 |
| 7 | ОНХСан | 383.3 | 365.4 | -17.9 |
| 8 | СХСан | 277.5 | 275.9 | -1.6 |
| 9 | Аймагт төвлөрүүлэх тэгшитгэл | 3,305.0 | 3,000.6 | -304,4 |
| | Нийт дүн | 8,238.6 | 7,881.4 | -357.2 |

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 онд 228.6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна.

Үүнд дээд шатны төсвийн захирагчаас нийт 204.9 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос 15.1 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 8.6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авч тээвэр шатахууны зардалд 3.1 сая, шуудан, холбо, интернэтийн төлбөр 0.04 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 223.9 сая, урсгал шилжүүлэг 1.6 сая нийт 228.6 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого ороогүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 1/110 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 9,772.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 146.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын илрүүлэлт:

Өлгий сумын шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Өлгий сумын Орон нутгийн хөгжлийн санд тайлант онд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 279,870.9 мянган төгрөгийн 28 гүйлгээ хийгдсэнээс 181,624.4 мянган төгрөгийн зарлагын 17 гүйлгээний мэдээллийг байршуулаагүй. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 388,200.0 мянган төгрөгийн 1 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 59.3 хувьтай байна

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа зөрчилтэй асуудал гараагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 заалттай албан шаардлага өгсөн ба зөрчлийг арилгаж албан шаардлагын биелэлтийг Өлгий сумын Засаг даргын орлогчийн 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн №2/485 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|----------|----------|----------|------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 1 | 0 | 1 | 0 | 100 |
| Зөвлөмж | | | | | |
| Нийт дүн | 1 | 0 | 1 | 0 | 100 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дараагийн аудитаар анхаарах зүйл байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой алдаа илрээгүй, залруулга хийгдээгүй болно.

Аудитаар 569.8 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага өгөгдсөн болно.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

1.Аудитаар 569.8 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгөв. Үүнд:

Өлгий сумын Орон нутгийн хөгжлийн санд тайлант онд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 279870.9 мянган төгрөгийн 28 гүйлгээ хийгдсэнээс 181624.4 мянган төгрөгийн зарлагын 17 гүйлгээний мэдээллийг байршуулаагүй. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 388200.0 мянган төгрөгийн 1 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 59.3 хувьтай байна

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 3 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллагыг түүвэрт хамруулсан, 2 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Ерөнхий боловсролын сургуулиуд, Хүүхдийн цэцэрлэгүүд, Эрүүл мэндийн төвийн орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 1,034.1 сая төгрөгийн алдааг залруулга хийж, 42.0 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 21.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Хүснэгт 4: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|-----------------|-------------------------------------|----------------------|----------------|-----------|----------------|---------------|-----|-----------------|-------------|----------|-------------|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Сумын ЗДТГазар | 5 | 1,097.4 | 2 | 1,034.1 | | | 2 | 42.0 | 1 | 21.3 |
| 2 | | | | | | | | | | | |
| Нийт дүн | | 5 | 1,097.4 | 2 | 1,034.1 | | | 2 | 42.0 | 1 | 21.3 |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

/мянган төгрөгөөр/

| Лдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|--------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--------------------|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|------------------|---------------|-----|-----------------|------------------|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| ОНХС-гийн шилэн дансны мэдээллийг дутуу байршуулсан | 1 | 569,824.2 | | | 1 | 569,824.2 | | |
| Дүн | 1 | 569,824.2 | | | 1 | 569,824.2 | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | | | | | |
|-----------------|----------|------------------|--|--|----------|------------------|--|--|
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | 1 | 569,824.2 | | | 1 | 569,824.2 | | |